БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА Б.МӨНХБАТ

2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр

“НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ-ЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны 01 дүгээр сарын 14

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Төсөв	Хугацаа	Хариуцах гишүүний нэр, хамтран ажиллах хэлтэс
1	2	3	4	5	6	7
Нэг. Зохион байгуулалтын үйл ажиллагааны талаар.						
1.	“Ёс зүйн дэд хороо”-ны 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд санал авч нэгтгэн, Газрын даргаар батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллах.	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	-	1 дүгээр сард	Ёс зүйн дэд хорооны нийт бүрэлдэхүүн
2.	“Ёс зүйн дэд хороо”-ны төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр нэгтгэж, Газрын даргад тайлагнах.	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100 хувь	-	6, 12 дугаар сард	Нарийн бичгийн дарга
3.	Ёс зүйн зөрчлийн талаарх мэдээ, тайланг тухай бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэх.	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	-	Тухай бүр	Нарийн бичгийн дарга
4.	Ёс зүйн дэд хорооны хурлын тэмдэглэлийг тухай бүр цаасан суурьтай албажуулах.	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	-	Тухай бүр	Нарийн бичгийн дарга

5.	“Ёс зүйн дэд хороо”-ны 2024 оны үйл ажиллагааны талаарх холбогдох материалын бүрдлийг ханган Газрын Архивд хүлээлгэн өгнө.	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	-	1 дүгээр сард	Нарийн бичгийн дарга
Хоёр. Ёс зүйн зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хариу арга хэмжээ авч ажиллах талаар.						
6.	Ажилтан, албан хаагчдын ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдол, мэдээллийг цаасан болон цахим хэлбэр (QR код)-ээр хүлээн авч бүртгэх.	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	-	Тухай бүр	Нарийн бичгийн дарга
7.	Ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдол мэдээллийн үндэслэлийг шалган тогтоож, хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд дүгнэлт гаргаж, дүгнэлтийг холбогдх газар, албан тушаалтанд хүргүүлэх.	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	-	Тухай бүр	Ёс зүйн дэд хорооны нийт бүрэлдэхүүн
8.	Ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийг тухайн албан хаагчийн хувийн хэрэгт хадгалах.	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	-	Тухай бүр	Нарийн бичгийн дарга
9.	Ёс зүйн хариуцлага хүлээсэн төрийн албан хаагчийг танхимын давтан сургалтад хувийн зардлаар хамруулна.	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	-	Тухай бүр	Ёс зүйн дэд хорооны нийт бүрэлдэхүүн
Гурав. Сургалт, соён гэгээрүүлэх урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаар.						
10.	Газрын ажилтан, албан хаагчдын “Ёс зүй, харилцаа хандлага”-ын талаар судалгаа авч, дүнг нэгтгэн Газрын даргад танилцуулах.	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	-	4-5 дугаар сард	Ёс зүйн дэд хорооны нийт бүрэлдэхүүн
11.	Газрын удирдах албан тушаалтнуудын “Ёс зүй, харилцаа хандлага”-ын талаар судалгаа авч, дүнг нэгтгэн Газрын даргад танилцуулах.	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	-	4-5 дугаар сард	Ёс зүйн дэд хорооны нийт бүрэлдэхүүн
12.	Шинээр томилогдсон ажилтан, албан хаагчдад Газрын “Ёс зүйн дүрэм”-ийг танилцуулж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтад хамруулах.	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	-	Тухай бүр	Ёс зүйн дэд хорооны гишүүн (Л.Гансүх, Л.Болорчулуун)
13.	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон холбогдох дүрэм, журмын талаар танилцуулга, мэдээлэл бэлтгэж Газрын	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	-	1-4 дүгээр улиралд	Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн

	дотоод сүлжээ, мэдээллийн самбарт 10-аас доошгүй удаа байршуулж, сурталчлах, мэдээлэх.					(Б.Батцэнгэл, Г.Ижилмаа)
14.	Газрын нийт албан хаагчдад "Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт"-ыг 2-оос доошгүй удаа зохион байгуулах (*Холбогдох хууль, тогтоомжийн талаар товч мэдээлэл танилцуулга болон Төрийн байгууллагад гарч буй авлига, хүнд суртал, ёс зүйн зөрчлийн бодит кейс, шийдвэрлэлтийн талаарх мэдээлэл, Төрийн албаны үнэт зүйлс, ёс зүй, харилцаа хандлага, Ажлын байрны хортой уур амьсгал г.м)*	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	1.000.000 төгрөг	1-4 дүгээр улиралд	Ёс зүйн дэд хорооны нийт бүрэлдэхүүн
15.	Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт нөлөөллийн өдөрлөг, үйл ажиллагааг улирлал тутам буюу нийт 4 удаа зохион байгуулах.	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	1.000.000 төгрөг	1-4 дүгээр улиралд	Ёс зүйн дэд хорооны нийт бүрэлдэхүүн
16.	Ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх чиглэлийн сургалтад Ёс зүйн дэд хорооны гишүүдийг хамруулна.	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	-	1-4 дүгээр улиралд	Ёс зүйн дэд хорооны нийт бүрэлдэхүүн

ХЯНАСАН:
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА Х.БАТХҮҮ

БОЛОВСУУЛСАН:
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Г.ИЖИЛМАА